



Ховд аймаг УИХ-ын 16 дугаар тойрог	
УИХ-ын гишүүн Р.АМАРЖАРГАЛ-ын ажлын тайлан	
Огноо	2009 оны Нэгдүгээр улирал
Дугаар	№01

УИХ-ын гишүүн Р.Амаржаргалын
Ажлын алба, Төрийн ордон-211
E-mail: arinchin@parliament.mn

Утас: (51)-260127
Факс: +(976)-11-310127
URL: www.amarjargal.org

Нэгдүгээр сар

2009.1.21-ны Лхагва гариг,

УИХ-ын Дарга Дамдингийн Дэмбэрэлтэй уулзан орон нутагт тулгамдаж буй цаг үеийн асуудлаар санал солилцов.

2009.1.22-ны Пүрэв гариг,

12.00 Үндэсний Статистикийн Ерөнхий Газрын Дарга Мэндсайхан, Сонгуулийн Ерөнхий Хорооны дэд дарга Содномцэрэн нарыг хүлээн авч уулзав.

15.00 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн түр хороо/PPP/-ийн ажлын хэсгийн гишүүдийн хурал хуралдав.

2009.1.23-ний Баасан гариг,

11.00 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн түр хороо/PPP/-ийн ажлын хэсгийн гишүүдийн хурал хуралдав.

2009.1.26-ны Даваа гариг,

Өдөр тутмын сонин хэвлэлүүдэд “Шүүх засаглалын тухай” мэдэгдэл хүргүүлэв. Мэдэгдэлд, өнөөгийн шүүх засаглалын гажуудал, алдаа завхралыг илчлэн шүүмжилсэн байна.

Хоёрдугаар сар

2009.02.03-ны Мягмар гариг,

11.00 Японы Элчин Сайдын Яамны Элчин зөвлөх ноён Варатаниг хүлээн авч уулзав.

11.30 Ша.Батбаяртай уулзаж “Өдрийн сонин”-д ярилцлага өгөв.2009.02.04,Лхагва гаригийн дугаарт нийтлэгдэв.

2009.02.05-ны Пүрэв гариг,

11.00 Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны Төрийн Нарийн бичгийн дарга Баясгалан, Хууль зүйн бодлогын газрын орлогч дарга Ж.Майзориг нарыг хүлээн авч уулзав.

2009.02.11-ны Лхагва гариг,

“Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” тогтоолийн төслийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оров.

11.00 25-р суваг телевизэд Санхүү эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн талаар ярилцлага өгөв.

14.00 ТВ5 тепевизийн “Зохиогчийн хөтөлбөр” нэвтрүүлэгт Санхүү эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн талаар ярилцлага өгөв.

2009.02.12-ны Пүрэв гариг

10.00 УИХ-ын ээлжит бус чуулганыг товлон зарлаж Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл, Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 06 дугаар дүгнэлттэй холбогдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус хэлэлцэхээр тогтоол гарав. Энэ өдрийн хуралдаанаар Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэв.

11.30 Commerce Bank-ны захиралын туслах н.Ганбатыг хүлээн авч уулзав.

17.30 Компанийн засаглалын асуудлаар USAID-ийн төлөөлөгч ноён Демиртэй уулзав.

2009.02.13

10.00 УИХ-ын ээлжит бус чуулган хуралдав. Энэ өдрийн хуралдаанаар Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэв.

2009.02.16-2009.02.19

Шри Ланка-ийн Коломбо хотод “Өлсөнлөнгийн асуудлаархи бүс нутгийн форум”-д оролцов.

2009.02.20

10.00 УИХ-ын ээлжит бус чуулган хуралдав. Энэ өдрийн хуралдаанаар Иргэдийн зорчих нөхцөлийг харилцан хөнгөвчлөх тухай, Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 06 дугаар дүгнэлттэй холбогдуулан НӨАТТухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус хэлэлцэв. Мөн Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах араг хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг болов.

14.30 Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаан хуралдав. Энэ өдрийн хуралдаанаар 2009 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэв

17.00 “Face to Face” English talk show-нд оролцов.

Гуравдугаар сар

2009.03.02 Даваа гариг

10.00-10.30 Азийн хөгжлийн банкны төлөөлөгч Боб Парра, Крис Дөүли, В.Лувсанчүлтэм нарыг хүлээн авч уулзав.

13.00-14.30 Дэлхийн Банкны суурин төлөөлөгч ноён Аршад М. Сайедтай уулзав.

2009.03.03 Мягмар гариг

10.00-13.00 УИХ-ын ээлжит бус чуулган хуралдав. Энэ өдрийн хуралдаанаар Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа. Мөн Иргэдийн зорчих нөхцөлийг харилцан хөнгөвчлөх тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад харилцааны яам хооронд солилцсон Ноот бичгийг соёрхон батлах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явагдав. Эцэст нь Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай хуралдав.

УИХ-ын гишүүн З.Алтай, Р.Амаржаргал нарын нэр бүхий УИХ-ын гишүүд Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл санаачилснаа УИХ-ын даргад өргөн бариллаа.

2009.03.04 Лхагва гариг

16.30 Санхүү эдийн засгийн дээд сургуулийн IV курсийн оюутнуудад лекц уншив.

2009.03.05 Пүрэв гариг

11.00 Японы Батлан Хамгаалахын Их Сургуулийн магистур н.Хишигсүрэнтэй уулзаж Цөмийн зэвсэггүй бүс нутгийн асуудлаар ярилцав.

13.00 Хөөрөх цэг сэтгүүлд ярилцлага өгөв.

20.00 Face to Face English Talk show-нд оролцов.

2009.03.06 Баасан гариг

10.00-13.30 УИХ-ын ээлжит бус чуулган хуралдав. Энэ өдрийн хуралдаанаар Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлэг болон бусад асуудлуудыг тус тус хэлэлцэв.

2009.03.09

14.00 УИХ дахь Ардчилсан Намын Бүлгийн хуралдаан хуралдав.

16.00 Ховд аймгийн Зэрэг сумын Эхэн багийн иргэн Б.Пүрэвдоржийг хүлээн авч уулзав.

2009.03.11-2009.03.13

Малайзын Куала Лумпур хотод Олон улсын Хөлбөмбөгийн Холбооны хуралд Монгол улсаа төлөөлөн оролцов.